ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2022 ОНЫ 4 ДҮГЭЭР САР

2022.07.05

Банкуудын зээл олголт, багц

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

Нийт актив
₮41.3 их наяд
Нийт зээл
₮22.5 их наяд
Хадгаламж
₮17.3 их наяд
Харилцах
₮8.2 их наяд
Өөрийн хөрөнгө
₮4.4 их наяд

Банкны салбарын ерөнхий тойм

Монгол улсад нийт 12 арилжааны банк байдаг. Улаанбаатар хот болон орон нутагт нийт 1,391 салбар нэгж, 15,921 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод нийт 409 салбар нэгж, гадаадад 4 салбар байршиж байна. Арилжааны банкуудаас Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк болон Хас банк нь системийн нөлөө бүхий банк юм.

Банкуудын зээл олголт, зээлийн багц

» Тайлант сард банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 28.9% өсөж, 22.5 их наяд төгрөг болсон байна. Тодруулбал өмнөх оны мөн үеэс хувийн байгууллагын зээл 28.8 хувиар өсч 10.5 их наяд төгрөгт, иргэдийн зээл 32.3 хувиар өсч 11.6 их наяд төгрөгт хүрчээ. Нийт зээлийн 1.4 их наяд төгрөг буюу 6.4% нь гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл, үлдсэн 93.6% нь төгрөгөөр олгогдсон зээл байна. Мөн зээлийн нийт үлдэгдлийн 46.4% нь хувийн байгууллага, 1.1% нь улсын байгууллага, 52.3% нь иргэдийн зээл, үлдсэн 0.2% нь бусад байгууллагуудад олгогдсон зээл байна.

» Тайлант сард олгогдсон ердийн зээлийн хувьд авч үзвэл төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хугацаа 34.8 сар, валют 16.6 сарын хугацаатай байна. Өмнөх тайлант сарын үзүүлэлтээс төгрөгийн болон гадаад валютын хугацаа 6 болон 2 хувиар өссөн үзүүлэлттэй харагдаж байгаа юм.

» Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 202.0 тэрбум төгрөгөөр буурсан бол эргэн төлөгдсөн зээл 44.1 тэрбум төгрөгөөр буурчээ. Доорх зурагт 4 дүгээр сард олгогдсон болон төлөгдсөн зээлийг өмнөх тайлант сартай харьцуулсан дэлгэрэнгүйг харуулав.

Зураг 1: 2022 оны 3-р сард олгосон, төлөгдсөн зээл (тэрбум төгрөг)



Зураг 2: 2022 оны 4-р сард олгосон, төлөгдсөн зээл (тэрбум төгрөг)

Эх сурвалж: Монголбанк

Банкуудын зээл олголт, багц

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

2022 оны 4 дүгээр сарын байдлаар нийт зээлийн багц 22.5 их наяд төгрөг байна. Өмнөх сартай харьцуулахад хувийн байгууллагын зээлийн багцын үлдэгдэл 386 тэрбум төгрөг, иргэдийн зээл 329 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Харин зээлийн багцын хувьд 21.0%-ийг бөөний болон жижиглэн худалдаа, 14.5%-ийг үл хөдлөх хөрөнгө, 7.8%-ийг уул уурхай болон барилга, 7.5%-ийг боловсруулах салбарт олгосон байна.

Харин тайлант сард олгогдсон зээлийн 71% буюу нийт 1,039.3 тэрбум төгрөгийн зээлийн багцыг иргэдийн хэрэгцээнд зориулсан бусад төрлийн зээлүүд бүрдүүлж байна. Энэ төрлийн зээлүүд нь нийт зээлийн багцын 26.4% буюу 5.9 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Эдгээр хэрэглээний зээлийн багцыг задлавал:
» 48.0% цалингийн зээл
» 2.4% автомашины зээл
» 18.3% малчны зээл
» 17.7% хадгаламж барьцаалсан зээл
» 3.1% картын зээл
» 8.2% тэтгэврийн зээл
» 1.6% өрхийн хэрэглээнд зориулсан зээл

Тайлант сард нийт хэвийн зээлийн дүн 18.8 их наяд төгрөг, үүний 57.6% нь 1-5 жилийн хугацаатай, 24.7% нь урт хугацаат зээлүүд байна. Харин чанаргүй зээл өмнөх сараас 11.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2,128.3 тэрбум төгрөг болсон байна.
Чанаргүй зээлийг бүтцээр нь задалбал:
26.7% - уул уурхай
18.2% - боловсруулах салбар
13.6% - барилга
7.3% - үл хөдлөх
7.9% - цалин тэтгэврийн зээл
6.1% - худалдаа
3.7% - хөдөө аж ахуйн зээл байна.
Мөн нийт чанаргүй зээлийн 9.2% нь гадаад валютын зээл байна.

Зураг 3: Зээлийн бүтэц, салбараар

Зураг 4: Зээлийн чанарын ангилал



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн жигнэсэн дундаж хүү

Зээлийн жигнэсэн дундаж хүү

2022 оны 4-р сарын нийт зээлийн үлдэгдлээр тооцсон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.96 нэгж хувиар буурч 15.36%, валютын хүү 0.07 нэгж хувиар өсч 9.48% болсон байна.

Харин шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү буурч 14.61% бол валютын зээлийн хүү 7.66% байна.

Тайлант хугацаанд шинээр олгосон зээл, шинээр татсан нийт хадгаламжийн хүүгийн зөрүү 6.8% гарсан ба өмнөх оны мөн үед уг зөрүү 9.1% байсан юм. Харин шинээр татсан хугацаатай хадгаламжийн дундаж хүүтэй харьцуулбал зөрүү 6.6% юм. 2021 онд ковид-19 цар тахлын эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулах хүрээнд Бодлогын хүүг 6 хувьд барьж байсан. Харин 2022 он гарснаар дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдлаас үүдэлтэй инфляцын хүлээлт өсөх, төлбөрийн тэнцэлийн алдагдал нэмэгдэхийн зэрэгцээ гадаад суурь хүү илүү хурдтай өсөх нөхцөл үүсэж байгаа нь мөнгөний бодлогын төлөвийг илүү хурдтай чангаруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагын хүрээнд бодлогын хүүгээ өсгөх шийдвэр гаргаснаар хадгаламжийн хүү өсөх хандлагатай байна.

Тус сар иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.1% байхад хувийн байгууллагуудад олгосон зээлийн хүү 14.2% байна.

Харин нийт үлдэгдлээр бол иргэдийн зээлийн хүү 15.8%, хувийн байгууллагынх 14.7% байна. Үлдэгдэлд болон олгосон зээлд тооцсон хүүгийн хувьд иргэдийн зээлийн хүү байгууллагын зээлийн хүүнээс илүү байгаа юм.

Зураг 5: Шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү



Зураг 6: Шинээр олгосон зээл, хадгаламжийн хүүгийн зөрүү



Зураг 7: Шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү, салбараар



Эх сурвалж: Монголбанк

Банкудын харилцах, хадгаламж, ипотекийн зээл

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

Нийт актив
₮41.3 их наяд
Нийт зээл
₮22.5 их наяд
Хадгаламж
₮17.3 их наяд
Харилцах
₮8.2 их наяд
Өөрийн хөрөнгө
₮4.4 их наяд

Банкуудын харилцах, хадгаламж

2022 оны 4-р сарын байдлаар нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 8.0%-аар буурч, харилцахын үлдэгдэл 29.9%-аар өссөн байна. Үүнээс, төгрөгийн хадгаламж 8.5%-аар, гадаад валютаар илэрхийлэгдэх хадгаламжийн хэмжээ 6.5%-аар буурсан нь иргэд, аж ахуйн нэгжүүд мөнгөө хадгалах сонирхол буурсныг илэрхийлж байна. Харин валютын харилцах хамгийн өндөр хувиар буюу 51.6% өсөлт үзүүлжээ.

Тайлант сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 7.9 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 1.7 хувь байна. Төгрөгийн хадгаламжийн ЖДХ өмнөх сараас 1.1 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 1.9 нэгж хувиар өссөн бол валютын хадгаламжийн ЖДХ харгалзан 0.3 болон 1.0 нэгж хувиар буурчээ. Зураг 9-д шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүүг харуулав.

Ипотекийн зээл олголт

2022 оны 4-р сард нийт 1,094 иргэнд нийт 112.5 тэрбум төгрөгийн зээлийг шинээр олгосон бөгөөд үүний 37.9% хувийг хөтөлбөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна. Сарын эцсийн байдлаар нийт 105,006 зээлдэгчийн 5.86 их наяд төгрөгийн ипотекийн зээл байна. Сарын турш нийт 112.5 тэрбум төгрөгийн шинэ зээл олгогдож, 52.6 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгджээ.

Зээлийн хугацааны хувьд дээд хугацаа нь 369 сар доод хугацаа 36 сар байгаа бол тайлант сард олгогдсон зээлүүдийн дундаж хугацаа 215 сар байна.

Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 7.39% хувьд хүрч, өмнөх сараас 0.08 нэгжээр буурав.

Тайланд сард нийт 153.9 тэрбум төгрөг хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн ангилалд байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй ангилалтай зээлийн задаргааг Зураг 10-т дэлгэрэнгүй харуулав.

*Зураг 8: *Хадгаламжийн хүү*



*Тайлбар: Шинээр татсан нийт хадгаламж болон хугацаатай хадгаламжийн хүү хоорондоо ялгаатайг анхаарна уу.

Зураг 9: Ипотекийн зээлийн эх үүсвэр /тэрбум.төг/



Зураг 10: Хугацаа хэтэрсэн болон чанаргүйд ангилагдсан ипотекийн зээлийн багц /тэрбум.төг/



Эх сурвалж: Монголбанк

Макро эдийн засгийн орчин

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

Макро эдийн засгийн орчин

Гадаад худалдааны тэнцэл:

Экспорт, импортийн нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 691 сая ам.долларoор өсч 5,149 сая ам.долларт хүрсэн байна. Үүнд экспорт 12%-аар буюу 303 сая ам.долларoор, импорт 20%-аар буюу 388 сая ам.долларoор өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 85 сая ам.долларoор буурч 450 сая ам.долларын ашигтай гарлаа.

Экспорт: 1.2 тэрбум ам.доллар (12%↑)

2022 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 12%-аар буюу 303 сая ам.долларoор өсч 2,799 сая ам.долларт хүрчээ. Экспорт нийт 12 хувиар өсөхөд 17 нэгж хувийг уул уурхайн бүтээгдэхүүний өсөлт бүрдүүлсэн байна.

Импорт: 1.0 тэрбум ам.доллар (20%↑)

2022 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20%-аар буюу 388 сая ам.долларoор өсч 2,349 сая ам.долларт хүрчээ. Импорт 20 хувиар өсөхөд хэрэглээний бүтээгдэхүүний импорт 12 нэгж хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 7 нэгж хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Инфляц, бодлогын хүү:

Улсын инфляц 2022 оны 4 дүгээр сарын байдлаар 2.4 хувь, жилийн инфляц 14.4 хувь байна. Улаанбаатар хотын хэмжээнд 15.2% гарав. Барааны бүлгээр авч үзвэл 10.4 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 4.8 нэгж хувийг хүнсний бараа бүрдүүлж байна. Хүнсний бүлгийн үнийн өсөлтөд талх, гурил, будааны үнэ, хүнснээс бусад барааны үнийн өсөлтөд шатахууны үнэ голлон нөлөөлжээ.

Гадаад валютын ханш, албан нөөц:

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш сарын эцсийн байдлаар 3083.88 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 4.6 хувиар, өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 3041.84 төгрөг байв.

Харин төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш өмнөх сараас 0.7 хувиар, өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар суларч 468.23 төгрөгт хүрэв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 466.31 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 479.26 төгрөг байлаа.

Зураг 11: Төгрөг ам.долларын эрэг (сарын хөдөлгөөнөөр)



Зураг 12 Төгрөг юанийн эрэг (сарын хөдөлгөөнөөр)



Эх сурвалж: Монголбанк

АНДЕРРАЙТЕРИЙН ХЭЛТЭС

Банк Реформер, IPO, Бонд, Хувьцаа

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

С.ТҮВШИНЗАЯА
Андеррайтерийн хэлтсийн дарга
9912-2583
tuvshinzaya@tavanbogdcapital.com

Б.МЯГМАРСҮРЭН
Шинжээч
9527-9442
myagmarsuren.b@tavanbogdcapital.com

Б.АНАНД
Шинжээч
9973-7090
anand.b@tavanbogdcapital.com

Б.ГАН-ЭРДЭНЭ
Хуулийн зөвлөх
8004-5151
ganerdene.b@tavanbogdcapital.com

9502-9966, 9502-4664, 9400-4442 cr@tavanbogdcapital.com www.tavanbogdcapital.com